

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ 03 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

2026 оны 03 дугаар сарын 31-ны өдөр

Орхон аймаг

1. Үндсэн үйл ажиллагаа:

Аймгийн Засаг даргын 2025 оны А/17 захирамжаар 12 орон тоотой байгууллагын стратеги төлөвлөгөөний 5 зорилгын хүрээнд 2026 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

1.1. Байгууллагын “Эрсдэлийн үнэлгээний журам”-ын дагуу 2026 оны Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан 55 байгууллагаас 2026 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар **13** байгууллагын хяналт шалгалт бүрэн дууссан, **5** байгууллагын хяналт шалгалт 50-90%-тай үргэлжилж байна.

Дотоод аудит, хяналт шалгалтын төрөл

Он	ДА, СХШ-ын төлөвлөгөө /төлөвлөгөөт бус тоо/	2026.03.26-ны байдлаар батлагдсан удирдамжийн тоо	Төлөвлөгөөт	Төлөвлөгөөт бус	Дотоод аудит	Санхүүгийн хяналт шалгалт
2026	55	18	18	-	15	3

2026 оны бүрэн дууссан хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт **24%-тай** байна.
Тайлбар: Хяналт, шалгалтын төлөвлөгөөний биелэлтийг өссөн дүнгээр мэдээллэж байгаа болно.

-Шалгалт бүрэн дууссан байгууллагууд:

1. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ
2. Их шүтээн ОНӨААТҮГ
3. Үйлс бадрах ӨЭМТөв
4. Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан
5. 20-р цэцэрлэг
6. 5-р цэцэрлэг
7. 2-р цэцэрлэг
8. 16-р цэцэрлэг
9. Жаргалант сумын хоршоо хөгжүүлэх сан
10. 11-р цэцэрлэг
11. 24-р цэцэрлэг
12. 4-р цэцэрлэг
13. 3-р цэцэрлэг

Дээрх байгууллагуудын гүйцэтгэсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарт танилцуулж, тогтоосон акт, албан шаардлага, ажил сайжруулах зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд хангуулан ажиллаж байна.

-Шалгалт бүрэн дуусаагүй байгууллагууд:

1. Баян-Өндөр сумын ОНХСан
2. Одод цэцэрлэг
3. 19-р цэцэрлэг

4. 10-р цэцэрлэг

5. 21-р цэцэрлэг

Дээрх байгууллагуудын 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэж байна.

1.2. Аймгийн Засаг даргын 2026.03.04-ний өдрийн А/195 дугаартай “Хяналт-шинжилгээ хийх тухай” захирамжаар Төрийн захиргааны байгууллагуудын 2025 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хэсэг 2026.03.16-ны өдрийн хуваарийн дагуу манай байгууллага дээр ажилласан. Байгууллагын 2025 оны үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг бэлтгэн, бэлтгэж ажлыг ханган ажиллаж, хяналт-шинжилгээ хийлгэсэн.



1.3. Шилэн ажиллагааны www.shilen.gov.mn сайтад 2026 оны I улирлын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нээлттэй мэдээллийг 5 бүлгийн 87 талбарт байршуулж 2026.03.09-ны өдөр тайланг илгээсэн.

Шил ажиллагаа

Шил ажиллагааны системд хиймэл оюуныг нэвтрүүлж эхэллээ

Асуулт асуух

Хянах самбар

Шилэн индекс

Тайлан бүртгэл

Тайлан нэгтгэл

Нээлттэй мэдээлэл

Зөв

ИАМ 36

АГЕНТАГ 9

Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудит

Нүүр / Индексийн тайлан

Индексийн тайлан

Тайлант үе: 2026 оны 1-р улирлын тайлан (2026-1) Төлөв: Сонгох Хайх Цэвэрлэх

Нийт: 10

#	Тайлант үе	Хувилбар	Төлөв	Төлөвийн огноо	Илгээсэн хэрэглэгч	Баталгаажсан үнэлгээний хувь
1	2026 оны 1 улирал	1	Илгээсэн	2026-03-09	dawaajargal819@gmail.com	0%

1.4. 03 дугаар сард албан хаагчдын дунд “Талархлын хайрцаг” аялуулж, бие биеэндээ талархсан сэтгэлээ илэрхийлэн, эерэг, тухтай, найрсаг хамт олон, ажлын байрыг бий болгоно ажиллалаа.




- 1.5. 2026.03.26-ны өдрийн 16 цагт Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоол, Онцгой байдлын газрын Улсын хяналтын байцаагчийн 2026.03.25-ны өдрийн 04/07 тоот мэдэгдлийн хүрээнд газрын 10 албан хаагч гамшгийн зарлан мэдээллийн дуут дохиогоор Онцгой байдлын газрын томилогдсон албан хаагчийн заавар, зөвлөмжийн дагуу дадлага, сургуульлалтад хамрагдлаа.



2. Сургалт, зөвлөгөөн:


- 2026.03.05-ны өдөр “Насан туршийн суралцахуйн төв”-тэй хамтран **“Компьютерт үндэсний бичгээр бичих дадлага”, “Үндэсний бичгийн зөв бичих дүрэм”** сэдэвт дотоод сургалт, дадлага ажлыг зохион байгууллаа. Сургалтад байгууллагын 10 албан хаагч хамрагдсан.




- Монгол Улсын Сангийн яам, Дэлхийн банктэй хамтран **“Дотоод аудиторуудыг чадавхжуулах, шинэчлэгдсэн стандарт ба арга зүйгээр хангах”** сургалт Улаанбаатар хотод 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан. Тус сургалтад байгууллагын 5 албан хаагч хамрагдлаа.



- 2026.03.23-ны өдөр “Насан туршийн суралцахуйн төв”-тай хамтран **“Ажлын байрны ёс зүй”** сэдэвт сургалт, хэлэлцүүлэг, дадлага ажилд байгууллагын бүх албан хаагч хамрагдсан.



- 2026.03.26-ны Монгол дахь Австралийн тэтгэтгэлт хөтөлбөрийн газар Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулсан “Австралийн тэтгэлэгт хөтөлбөр–2027” тэтгэлгийн талаарх мэдээлэл өгөх цахим уулзалтад байгууллагын ХШҮХМэргэжилтэн хамрагдлаа.
- 2026.03.26-ны өдөр Бүх хайраа гэр бүлдээ төслийн хүрээнд “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар”, “Зүрх сэтгэлийн карьер” ТББ, байгууллагын Эцэг эхийн зөвлөл хамтран **“ХАМТДАА ШАЛГАЯ, ХАМГААЛЪЯ”** сургалтыг албан хаагчдад зохион байгууллаа.



3. Үүрэг даалгавар:

- **Засаг даргын өргөтгөсөн хурал 2026-03-06 үүрэг даалгавар:** Иргэдтэй хийх уулзалтын үеэр иргэдээс гарсан нийт 125 арга хэмжээ бүхий төлөвлөгөөний гүйцэтгэлийг удирдлагуудаас асууж тодруулах тул анхаарч ажиллах.

Биелэлт: Байгууллагад хамааралтай санал иргэдээс гараагүй.

- **Засаг даргын өргөтгөсөн хурал 2026-03-06 үүрэг даалгавар:** Аймгийн Засаг дарга 2025 онд байгууллагууд дээр ажиллах үед тухай байгууллагуудаас болон ажилчдаас гарсан санал хүсэлтийн хэрэгжилтийг танилцуулах

Биелэлт: Аймгийн Засаг дарга 2025 онд байгууллагууд дээр ажиллах үед манай байгууллагаас болон ажилчдаас гарсан санал, хүсэлтийн хэрэгжилтийг тогтоосон хугацаанд аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлж ажилласан.

- **Засаг даргын өргөтгөсөн хурал 2026-03-13 үүрэг даалгавар:** Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагууд болон аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийн эзэмшлийн болон ойр орчмын 50 метр хүртэлх талбайг тохижуулах ажлын төлөвлөгөө боловсруулж батлан, Хотын захиалагчийн албанд

хүргүүлэх. Дээрх тохижилтын ажлын төлөвлөгөөг Аймгийн Засаг даргын өргөтгөсөн хурлын үүрэг даалгаварт хавсралт болгон ирүүлэх. Ойн арга хэмжээг угтан хэрэгжүүлсэн ажлын тайланг хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нотлох баримтын хамт тусган, Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлэх.

Биелэлт: Захиргааны III байранд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудтайгаа нэгдэн "Эрдэнэт хотын 50 жилийн ойд зориулсан бүтээлч ажлын төлөвлөгөө"-г хамтран гаргасан. Төлөвлөсөн ажлыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэн холбогдох тайланг байгууллагын 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлттэй хамт аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж ажиллана.

- **Засаг даргын өргөтгөсөн хурал 2026-03-20 үүрэг даалгавар:** Эрдэнэт хот байгуулагдсаны 50 жилийн ойн арга хэмжээг угтаж хийх ажлын төлөвлөгөөг аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т ирүүлэх. И-оффиссын дотоод мэйл хаягаар PDF ээр ирүүлэх.

Биелэлт: "Эрдэнэт хот байгуулагдсаны 50 жилийн ойн арга хэмжээг угтаж хийх ажлын төлөвлөгөө"-г гаргаж, аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн.

БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА: Сангийн яам, Дэлхийн банктай хамтран 2026 оны 03 дугаар 20-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан “Дотоод аудитуудыг чадавхжуулах, шинэчлэгдсэн стандарт ба арга зүйгээр хангах” сэдэвт сургалтад Газрын дарга **“Нэгдсэн менежментийн тогтолцоо”** хэрэгжүүлсэн сайн туршлагаа яамдын төрийн нарийн бичгийн дарга нар, нийслэл, дүүргийн засаг дарга нар, нийслэлийн 9 дүүргийн, 21 аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга, дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нарт хуваалцлаа. Сургалтад 160 гаруй төрийн албан хаагч оролцсон.



4 ДҮГЭЭР САРД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АЖЛУУД:

- Төлөвлөгөөт хяналт шалгалтууд хуваарийн дагуу явагдана.
- Байгууллагын төлөвлөгөөт дотоод сургалтууд тогтмол зохион байгуулагдана.
- Эрдэнэт хот байгуулагдсаны 50 жилийн ойн арга хэмжээг угтан хийх ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдэнэ.
- Цаг үеийн болон төлөвлөгөөт бус байгууллагад холбогдох арга хэмжээнд тогтмол идэвхтэй оролцоно.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР